

Тус бичиг нь эх бичгийг ойлгоход тус болгохоор бэлтгэсэн зүйл юм.  
Эрүүл мэндийн газраас гаргасан япон хэлээр бичигдсэн эх бичиг нь албан ёсны бичиг болно.

③

ЭМ газар № \_\_\_\_\_  
он сар өдөр

\_\_\_\_\_ танаа

\_\_\_\_\_ эрүүл мэндийн газрын дарга

### Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийг шаардах бичиг

он сар өдрийн ЭМ газар № \_\_\_\_\_ бичгээр таныг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай гэж мэдэгдсэний дагуу “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ба халдварт өвчнийг эмчлэх тухай” хуулийн (цаашид “хууль” гэх) 20-р зүйлийн 1 дэх хэсэг (26-р зүйл болон 26-р зүйлийн 2 дэх хэсгийг мөрдлөг болгох)-ийн заалтад үндэслэн дараах байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийг шаардаж байна.

Хэрэв эмнэлэгт хэвтэх хугацаа дуусахаас өмнө эмнэлгээс гарах нөхцөл хангагдаагүй бол эмнэлэгт хэвтэх хугацааг сунгах болно.

Хэрэв энэ шаардлагыг дагаж мөрдөхгүй бол Ковид-19-ийг тусгай заалттай халдварт өвчин гэж тодорхойлсон болон бусад Засгийн газрын тушаалын 3-р зүйлийн заалтад үндэслэн, хуулийн 20-р зүйлийн 2 дахь хэсэг (хуулийн 26-р зүйл болон 26-р зүйлийн 2 дахь хэсгийг мөрдлөг болгох)-ийг мөрдлөг болгож, албаар эмнэлэгт хэвтүүлэх арга хэмжээ авч болзошгүй.

#### 1 Хэвтэн эмчлүүлэх эмнэлэг

(1) Эмнэлгийн нэр

(2) Хаяг

#### 2 Хэвтэн эмчлүүлэх хугацаа

он сар өдрөөс он сар өдөр хүртэл

Эмнэлэгт хэвтэж буй хугацаанд эмнэлгээс гарах нөхцөл хангагдаагүй тохиолдолд

он сар өдрөөс он сар өдөр

хүртэл хэвтэн эмчлүүлэх хугацааг сунгах болно.

#### 3 Эмнэлэгт хэвтэхийг шаардах шалтгаан

(1) Халдварт өвчний тархалтыг зогсоох зорилгоор

(2) Халдварт өвчний шинж тэмдэгтэй учраас

#### 4 Бусад

Та хуулийн 22-р зүйлийн 3 дахь хэсэг (хуулийн 26-р зүйлийг мөрдлөг болгох)-ийн заалтын дагуу эмнэлгээс гарах хүсэлт гаргах боломжтой бөгөөд түүний дүнд уг халдварт өвчин үүсгэгч вирус илрэхгүй байх эсвэл тус халдварт өвчний шинж тэмдэг арилсан гэдэг нь батлагдвал хуулийн 22-р зүйлийн 1 дэх хэсэг (хуулийн 26-р зүйлийг мөрдлөг болгох) заалтад үндэслэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацаа дуусгавар болно.

Тус бичиг нь эх бичгийг ойлгоход тус болгохоор бэлтгэсэн зүйл юм.  
Эрүүл мэндийн газраас гаргасан япон хэлээр бичигдсэн эх бичиг нь албан ёсны бичиг болно.

Түүнчлэн хуулийн 24-р зүйлийн 2-ын 1 дэх хэсгийн заалтад үндэслэн таныг эмнэлэгт хэвтэж байсан хугацаанд хэрхэн хүлээж авсан талаар бичгийн хэлбэрээр эсвэл аман хэлбэрээр гомдол гаргах эрхтэй.

Энэ бичиг нь эмнэлэгт хэвтэх хугацаа нь сунгагдах тохиолдолд (анх удаа сунгахад) түүнийг мэдэгдэх бичгийн үүргийг давхар гүйцэтгэх болно. Харин та эмнэлэгт хэвтэх хугацаа сунгагдахыг хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулсан тохиолдолд албан ёсоор танд шаардлага тавих үүднээс тусгайлан бэлдсэн бичиг илгээх болно.

Хариуцсан ажилтан: \_\_\_\_\_